



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН АВТО ЗАМЫН САН – ТӨЛБӨР АВАХ ЦЭГИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/05/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261740 Цахим хаяг: bolorerdened@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ашид баланс аудит ХХК
Захирал: Л.Майцэцэг Цахим хаяг: ashidbalance@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ
Х.ПҮРЭВЖАРГАЛ ТАНАА

2022.03.25 № 07/694
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улсын авто замын сан-Төлбөр авах цэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын авто замын сан-Төлбөр авах цэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,745,409,600.94	1,061,987,144.76
31	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	226,569,848.93	226,569,848.93
31213	Арилжааны банк дахь харилцах	226,569,848.93	226,569,848.93
33	Авлага	361,163.41	0.00
3351	Байгууллагаас авах авлага	361,163.41	0.00
34	Урьдчилгаа	4,464,296,140.00	775,156,802.00
34600	Урьдчилж төлсөн зардал	4,464,296,140.00	775,156,802.00
35	Бараа материал	54,182,448.60	60,260,493.83
353	Бэлэн бүтээгдэхүүн	6,740,918.60	10,401,775.72
354	Хангамжийн материал	47,441,530.00	49,858,718.11
35410	Бичиг хэргийн материал	4,608,930.00	11,489,028.45
35420	Аж ахуйн материал	464,000.01	16,010,687.01
35430	Сэлбэг хэрэгсэл	412,500.00	692,500.00
35470	Бусад хангамжийн материал	41,956,099.99	21,666,502.65
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,253,374,759.69	6,448,722,200.39
39	Үндсэн хөрөнгө	1,253,374,759.69	6,448,722,200.39
392	Биет хөрөнгө	1,253,374,759.69	6,444,762,200.39
39201	Барилга,байгууламж,орон сууц	1,182,125,934.85	5,805,052,126.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	95,161,209.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	222,220,757.80	222,220,757.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	222,220,757.80	222,220,757.80
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	364,075,300.00	961,657,883.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	309,286,266.46	353,727,926.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,225,550.00	147,657,523.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	16,765,758.70	20,716,197.20
393	Биет бус хөрөнгө	0.00	3,960,000.00
39301	Програм хангамж	820,000.00	6,760,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	820,000.00	2,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ҮР ДҮН	5,998,784,360.63	7,510,709,345.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,998,784,360.63	7,510,709,345.15
512	Хуримтлагдсан үр дүн	5,614,233,003.62	7,126,157,988.14
51210	Өмнөх үеийн үр дүн	1,916,691,531.10	5,614,233,003.62
51220	Тайлант үеийн үр дүн	3,697,541,472.52	1,511,924,984.52
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	384,551,357.01	384,551,357.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,998,784,360.63	7,510,709,345.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН	54,456,526,712.92	4,640,140,320.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,656,526,712.92	4,640,140,320.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,656,526,712.92	4,640,140,320.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,648,005,712.92	4,639,640,320.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,648,005,712.92	3,000,000,000.00
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	1,639,640,320.00
120009	Бусад орлого	8,521,000.00	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	45,800,000,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	45,800,000,000.00	-
1310001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	45,800,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,188,036,245.27	3,128,285,335.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,240,529,624.57	3,128,285,335.48
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	3,057,050,697.11	3,117,820,468.48
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	2,000,378,015.60	2,218,429,466.63
210101	Цалингийн зардал	1,997,627,403.48	1,215,092,558.08
210102	Нэмэгдэл цалин	2,750,612.12	1,003,336,908.55
2102	Ажил олгогчоос НДШ-ийн зардал	253,100,401.68	297,293,846.53
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	171,043,472.26	205,526,882.84
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	22,347,881.44	22,873,809.46
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	16,020,933.02	18,549,971.54
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	3,954,201.01	4,562,733.76
210105	Эрүүл мэндийн даатгалын хураамж	39,733,913.95	45,780,448.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,700,814.36	93,629,660.35
210301	Гэрэл, цахилгаан	107,055,364.36	87,093,685.35
210302	Түлш, халаалт	6,645,450.00	6,535,975.00
2104	Хангамж, бараа материалын зардал	96,905,302.80	100,566,310.22
210401	Бичиг хэрэг	4,334,358.00	5,058,098.55
210402	Тээвэр, шатахуун	70,568,764.00	77,471,848.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	7,323,757.00	13,892,365.67
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	88,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,456,131.00	2,790,979.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,539,080.00	1,233,019.00
210408	Бараа материал акталсны зардал	1,595,212.80	-
2105	Нормативт зардал	60,942,300.00	11,935,277.54
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	60,942,300.00	11,935,277.54
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	108,498,301.00	67,825,468.81
210601	Багаж, техник, хэрэгсэл	58,821,681.00	7,555,728.00
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	34,401,870.00	47,075,710.81
210604	Урсгал засвар	15,274,750.00	13,194,030.00
2107	Томилолт, зочны зардал	17,036,800.00	9,456,340.00

Улсын авто замын сан – Төлбөр авах цэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	17,036,800.00	9,456,340.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	194,576,953.31	165,217,336.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	156,250,166.67	96,193,592.99
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	377,784.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	463,915.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	819,500.00	5,490,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,408,069.04	23,131,600.24
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	31,235,518.60	36,902,142.88
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	211,911,808.36	153,466,762.29
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	211,911,808.36	153,466,762.29
213	Урсгал шилжүүлэг	183,478,927.46	10,464,867.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,038,197.00	10,464,867.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,388,197.00	2,724,867.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,650,000.00	7,740,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	168,440,730.46	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	168,440,730.46	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,947,506,620.70	-
2200	Дотоод эх үүсвэрээр	46,947,506,620.70	-
223001	Бусад хөрөнгө	46,947,506,620.70	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	4,268,490,467.65	1,511,854,984.52
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	70,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	70,000.00
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	570,948,995.13	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	570,948,995.13	-
6	НИЙТ ҮР ДҮН	3,697,541,472.52	1,511,924,984.52

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,916,691,531.10	1,916,691,531.10
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	384,551,357.01	-	384,551,357.01
Тайлант үеийн үр дүн	-	-	3,697,541,472.52	3,697,541,472.52
2020 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	-	384,551,357.01	5,614,233,003.62	5,998,784,360.63
Тайлант үеийн үр дүн	-	-	1,511,924,984.52	1,511,924,984.52
2021 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	-	384,551,357.01	7,126,157,988.14	7,510,709,345.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	54,456,526,712.92	3,000,500,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,656,526,712.92	3,000,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,656,526,712.92	3,000,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,648,005,712.92	3,000,000,000.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,648,005,712.92	3,000,000,000.00
120009	Бусад орлого	8,521,000.00	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	45,800,000,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	45,800,000,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	45,800,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,063,170,247.22	3,000,500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,063,170,247.22	3,000,500,000.00
210	Бараа, ажил, үйлчилгээний зардал	2,894,729,516.76	3,000,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,894,729,516.76	3,000,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,894,729,516.76	3,000,500,000.00
213	Урсгал шилжүүлэг	168,440,730.46	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	168,440,730.46	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	168,440,730.46	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	51,393,356,465.70	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	102,839,335,121.40	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	102,839,335,121.40	-
2200	Дотоод эх үүсвэрээр	102,839,335,121.40	-
223001	Бусад хөрөнгө	51,419,667,560.70	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(102,839,335,121.40)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(51,445,978,655.70)	-
9	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	226,569,848.93	226,569,848.93
10	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	226,569,848.93	226,569,848.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,000,000,000.00	3,000,000,000.00	-	100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,000,000,000.00	3,000,000,000.00	-	100
210	БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,986,972,083.50	2,989,535,133.00	(2,563,049.50)	100
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,188,462,100.00	2,218,429,466.63	(29,967,366.63)	101
210101	Үндсэн цалин	1,253,245,400.00	1,215,092,558.08	38,152,841.92	97
210102	Нэмэгдэл урамшуулал	935,216,700.00	1,003,336,908.55	(68,120,208.55)	107
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	295,442,383.50	297,293,846.53	(1,851,463.03)	101
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	207,903,899.50	205,526,882.84	2,377,016.66	99
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	21,884,621.00	22,873,809.46	(989,188.46)	105
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	17,507,696.80	18,549,971.54	(1,042,274.74)	106
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	4,376,924.20	4,562,733.76	(185,809.56)	104
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	43,769,242.00	45,780,448.93	(2,011,206.93)	105
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,180,000.00	93,629,660.35	23,550,339.65	80
210301	Гэрэл цахилгааны зардал	109,080,000.00	87,093,685.35	21,986,314.65	80
210302	Түлш, халаалтын зардал	8,100,000.00	6,535,975.00	1,564,025.00	81
210303	Цэвэр, бохир усны зардал	-	-	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	103,650,000.00	118,150,025.26	(14,500,025.26)	114
210401	Бичиг хэргийн зардал	7,960,000.00	13,218,100.00	(5,258,100.00)	166
210402	Тээвэр, шатахуун	76,150,000.00	77,047,531.59	(897,531.59)	101
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	10,740,000.00	13,892,365.67	(3,152,365.67)	129
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	120,000.00	(120,000.00)	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,800,000.00	13,872,028.00	(5,072,028.00)	158
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-	-	-
2105	Нормативт зардал	10,000,000.00	2,890,000.00	7,110,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,000,000.00	2,890,000.00	7,110,000.00	29

Улсын авто замын сан – Төлбөр авах цэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,130,000.00	80,807,601.00	(3,677,601.00)	140
210601	Багаж техник хэрэгсэл	10,530,000.00	14,704,800.00	(4,174,800.00)	140
210602	Тавилга эд хогшил	-	8,390,000.00	(8,390,000.00)	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	45,000,000.00	38,830,000.00	6,170,000.00	86
210604	Урсгал засвар	21,600,000.00	18,882,801.00	2,717,199.00	87
2107	Томилолт, зочны зардал	13,057,600.00	9,456,340.00	3,601,260.00	72
210702	Дотоод томилолт	13,057,600.00	9,456,340.00	3,601,260.00	72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	182,050,000.00	168,878,193.23	13,171,806.77	93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	129,330,000.00	96,193,592.99	33,136,407.01	74
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	3,500,000.00	-	100
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	-	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	-	500,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-	-	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	10,000,000.00	5,490,000.00	4,510,000.00	55
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,500,000.00	23,131,600.24	(17,631,600.24)	421
210809	Улсын тэмдэгтийн маягт хэвлэх, бэлгэх	33,220,000.00	40,563,000.00	(7,343,000.00)	122
2109	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	-	-	-	-
210901	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	-	-	-	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,027,916.50	10,464,867.00	2,563,049.50	100
	Бусад урсгал шилжүүлэг	13,027,916.50	10,464,867.00	2,563,049.50	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,027,916.50	2,724,867.00	1,303,049.50	68
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00	7,740,000.00	1,260,000.00	86
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	-

Улсын авто замын сан – Төлбөр авах цэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	-
223001	Бусад хөрөнгө	-	-	-	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,000,000,000.00	3,000,000,000.00	-	100
31	Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	-
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	-
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,000,000,000.00	3,000,000,000.00	-	100
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000,000.00	3,000,000,000.00	-	100
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,600.00	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	19,600.00	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	139.00	229.00	90.00	165
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	-
620003	Үйлчлэх ажилтан	138.00	228.00	90.00	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	139.00	229.00	90.00	-
650010	Гэрээт ажилтан	-	224.00	-	-
650011	Улс төрийн албан хаагч /УТ/	-	-	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Авто замын сан-Төлбөр хураах цэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад гэрээний дагуу олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг аккурэл сууриар бүртгэж, авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулж байх, Хувь хүний орлогын албан татварын хуулийг хэрэгжүүлж ажиллах, татварын албатай жилийн эцсийн татварын үлдэгдлийг баталгаажуулж илүү төлсөн албан татварыг буцаан авах бусад татварт шилжүүлэн тооцож байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Ашид баланс аудит ХХК-ийн захирал Л.Майцэцэг, ахлах аудитор Д.Гандолгор, аудитор Д.Алтанцэцэг, аудиторын туслах Д.Сэрчинмаа нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Л.Оюунчимэг хэрэгжүүлсэн.

Улсын авто замын сан-Төлбөр авах цэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/124 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улсын авто замын сангийн хуулиар хүлээсэн чиг үүргийн нэг нь олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчсон тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр хураамж авах үйл ажиллагааг зохион байгуулах явдал юм.

Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйл Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 10.1.7 “тусгай зориулалтын авто зам барих, засварлах, ашиглахтай холбоотой журмыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах” гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/116 дугаар тушаалаар “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам”-ыг баталсан байна.

Журмын 1 дүгээр зүйлийн 1.4 “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах үйл ажиллагааг авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ыг зохион байгуулж хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Журмын 4 дүгээр зүйлийн 4.1 “Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нь олон улс, улсын чанартай авто замын тогтоосон чиглэлд төлбөр авах цэг байгуулан үйл ажиллагааг зохион байгуулж, авто зам ашигласны төлбөрийн орлогыг улсын авто замын санд төвлөрүүлнэ” гэж заасны дагуу Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс төлбөр, хураамж авах үйл ажиллагааг 28 төлбөр авах цэгээр дамжуулан зохион байгуулж, орлогыг төвлөрүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулсан.
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/116 дугаар тушаал “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам”
- Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын 2021 оны А/115 тугаар тушаал “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх”, “Цагаан жагсаалт”-д бүртгэх түр журам
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг Замын-Үүд, Мандалговь, Айраг, Цогт-Овоо, Онгийн гүүр, Түйн гүүр, Есөнбулаг, Хандгайт, Сонгино, Их-Уул, Тариат, Ганц мод, Хархорин, Эрдэнэсантын төлбөр авах цэгүүдэд хяналт шалгалт хийж, хугацаатай 31 үүрэг даалгавар өгч, 26 зөрчлийг илрүүлэн, залруулах арга хэмжээг авч, зайлшгүй ноцтой 3 зөрчилд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын авто замын сан - Төлбөр авах цэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 5,998.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 59.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улсын авто замын сан - Төлбөр авах цэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,511.9 сая төгрөгөөр буюу 25 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	226,569.9	226,569.9	-
Авлага	361.2	-	(361.2)
Урьдчилгаа	4,464,296.1	775,156.8	(3,689,139.3)
Бараа материал	54,182.4	60,260.5	6,078.1
Үндсэн хөрөнгө	1,253,374.8	6,448,722.2	5,195,347.4
Нийт хөрөнгө	5,998,784.4	7,510,709.4	1,511,925.0
Хуримтлагдсан үр дүн	5,614,233.0	7,126,158.0	1,511,925.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,998,784.4	7,510,709.4	1,511,925.0

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 226.6 сая төгрөг байгаа нь 2018 онд Авто замын сангийн санхүүжилтээр Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвийн хэсэгчилсэн 2.4 км хатуу хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгэх гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилт ХААН банкны харилцах дансанд байршиж байна.

Авлага дансны 0.4 сая төгрөгийн ажилчин албан хаагчаас авах авлагыг оны эцэст барагдуулж авлагын данс үлдэгдэлгүй гарсан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 775.2 сая төгрөг болж, 3,689.1 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2021 оны 597 дугаар тогтоолын дагуу 2 авто пүү, төлбөр авах цэгийн 9 байр, тоног төхөөрөмжийг тус тус үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 60.3 сая төгрөг болж, 6.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 125.0 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж, 118.9 сая төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,448.7 сая төгрөг болж, 5.2 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

ТӨБЗГ-ын 2021 оны 597 дугаар тогтоолын дагуу бүртгэж авсан 5,039.6 сая, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/538 дугаартай албан бичгийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 289.2 сая, шинээр худалдан авсан 14.4 сая, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/933 албан бичгийн дагуу ангилал хооронд шилжиж 5.9 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө ТӨБЗГ-ын 2021 оны А-1/396 дугаартай албан бичгийн дагуу акталсан 7.5 сая, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/933 албан бичгийн дагуу ангилал хооронд шилжүүлсэн 0.7 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус буурсан байна. Тайлант хугацааны хуримтлагдсан элэгдлийн зардал 145.5 сая төгрөг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төлбөр авах цэгийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,000.0 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,000.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 3,000.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу төсөвт зардлыг хэмнэх, төсвийг үр ашигтай зарцуулах чиглэлийг баримтлан ашиглалтын зардал, нормативт зардал, томилолтын зардал, мэдээлэл технологийн зардлыг 40 хувийн хэмнэлтэй зарцуулж ажилласан боловч тайлант хугацаанд шинээр төлбөр авах 8 цэгийн байрыг ашиглалтад оруулж, зайлшгүй шаардлагатай ажилчдын байрыг тохижуулахад зориулсан ширээ, сандал, аж ахуйн зардал, хангамжийн зардал мөн гэрээт ажилчдын цалин, нийгмийн даатгал, бичиг хэргийн зардлуудыг гаргасан байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	21	Урсгал зардал	3,000,000.0	3,000,000.0	-	100
1.1	210	Бараа ажил, үйлчилгээний зардал	2,986,972.1	2,989,535.1	(2,563.0)	100.1
1.2	2132	Бусад урсгал шилжүүлэг	13,027.9	10,464.9	2,563.0	80.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны “Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 103 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/116 дугаар тушаалыг мөрдлөг болгон олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр хураамж авах үйл ажиллагааг төлбөр авах 28 цэгээр дамжуулан зохион байгуулан ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас тус төлбөр авах цэгийн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд нийт 82 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн 56, 70-99 хувийн 15, 31-69 хувийн 2, хугацаа болоогүй 6, хасагдсан 1 арга хэмжээ байгаа ба нийт 95.6 хувийн биелэлттэй гэж үнэлсэн байна.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд 25,000.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 10,031.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөний биелэлт 40.1 хувьтай байна. Тайлант хугацаанд шинээр төлбөр авах 8 цэг ашиглалтад орсон боловч 8 дугаар сарын 01-ний өдрөөс төлбөр авах 7 цэгийн үйл ажиллагаа эхэлсэн байна. Мөн Ковид-19 цар тахлын улмаас хөдөлгөөний хязгаарлалттай байсан нь орлогын төлөвлөгөө дутуу биелэхэд нөлөөлсөн байна.

Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр хураамжийн орлогыг Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн сангийн дансанд төвлөрүүлж байна.

3.8 Аудитын гол асуудал

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улсын авто замын сан-Төлбөр авах цэг нь 2021 онд нийт 4,075.4 сая төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 100 хувь бүрэн байршуулсан байна.

Төлбөр авах цэг нь шилэн дансны мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яамны шилэн дансны цахим хуудсанд мэдээлдэг байсныг өмнөх аудитын зөвлөмжийн дагуу shilendans@mof.gov.mn сайтад хүсэлтээ илгээснээр 2021 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс бие даасан шилэн дансны цахим хуудсанд мэдээллээ оруулдаг болсон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай нийцэж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан “Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг баталсны дагуу Налайх, Хоолт, Эмээлт, Түргэний гүүр Төлбөр авах цэгүүдийг цахимжуулж олон улс, улсын чанартай авто замын төлбөр авах үйл ажиллагааг дугаар таньдаг камер болон RFID технологийн тусламжтайгаар автоматжуулсан байна.

Төлбөр хураамжийг цахимаар авах талаар Сангийн яамны харьяа “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-тай гэрээ байгуулан төлбөр хураамжийг и баримт аппликейшнд холбож туршилтыг амжилттай хийжээ. Төлбөр авах цэгүүдийг цахимжуулснаар төлбөр авах цэгийн үйл ажиллагааны зардал буурч төлбөр авах цэг дээр үүсдэг хөдөлгөөний ачаалал буурсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авч, хөрөнгө оруулалт хийгээгүй байна. Харин цахим засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд төлбөр авах цэгийг цахимжуулах ажил хийж эхэлсэн байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 4,444.4 сая төгрөгийн 1 алдаа зөрчил илрүүлснийг холбогдох төрийн байгууллагын шийдвэрийг гаргуулж үндсэн хөрөнгөнд бүртгэх тухай 1 зөвлөмж өгсөн. Тайлант хугацаанд урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй төлбөр авах цэгийн барилга, тоног төхөөрөмжийг хүлээн авч ТӨБЗГ-ын 2021 оны 597 дугаар тогтоолын дагуу 2 авто пүү, төлбөр авах цэгийн 9 байр, тоног төхөөрөмжийг тус тус үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.2 сая төгрөгийн зөрчилд тогтоосон 1 төлбөрийн акт биелсэн, авто замын сан бие даасан шилэн дансны цахим хуудасгүй яамны цахим хуудсанд давхар мэдээлдэг, мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг арилгах 1 албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна. Аудитаар өгсөн 6.7 сая төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	216.0	1	216.0	-	-	-
Албан шаардлага	1	-	1	-	-	-	-
Зөвлөмж	3	6,701.8	3	6,701.8	-	-	-
Нийт дүн	5	6,917.8	5	6,917.8	-	-	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Авто замын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 116 дугаар тушаалаар баталсан Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журмын 3, 4 дүгээр заалтуудыг үндэслэн Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн орлогыг батлагдсан төсөвтэй уялдуулан Улсын авто замын сан-төлбөр авах цэгийн тайланд тусгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12.5 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 12.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 12.5 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 59.9 сая төгрөгөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга гараагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Нэр бүхий 3 ажилтанд амралтын цалин илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчим” гэж заасантай нийцэхгүй, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

1. Удирдлагын шийдвэр, цагийн бүртгэлгүй нэр бүхий 8 ажилтанд баяр ёслолын нэмэгдэл цалин, 7 ажилтанд цагийн бүртгэлийн системээр баталгаажуулаагүй илүү цагийн хөлс олгосон, нэр бүхий ажилтанд үр дүнгийн урамшуулал олгохдоо хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журамд нийцүүлээгүй нийт 12.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх”, ЗТХТ-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 10 дугаар зүйлийн 10.2.9 “...илүү цагаар болон байнгын бэлэн байдлын үед ажиллах тохиолдолд...төвийн захирлын тушаалаар олгоно”, 11 дүгээр зүйл “цалин, урамшуулал”, Ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журмын 9.1.4 “үр дүнгийн гэрээний үнэлгээг үндэслэн дараах хувь хэмжээгээр үндсэн цалингаас тооцон үр дүнгийн урамшууллыг олгоно” гэсэн гэж заасантай тус тус нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Төлбөр авах цэгээр дамжин өдөр тутам олон удаагийн давтамжаар үйлчлүүлж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүстэй гэрээ байгуулан төлбөрийг авч байгаа боловч гэрээний дүнгээр төлбөрийн авлага үүсгэхгүй төлбөр хийгдсэн тухай бүр бүртгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж

Гэрээний дагуу олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг урьдчилж орсон орлогоор бүртгэж төлбөр хийгдсэн гүйцэтгэлээр төлбөрийн орлогыг хүлээн зөвшөөрч гэрээг дүгнэж, тооцоо нийлсэн актаар авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулж байх.

2. Татварын багц хуулиудын хэрэгжилт

2.1 Илрүүлэлт:

ХХОАТ тооцооллыг жилийн дүнгээр тулган баталгаажуулахад ажилчдаас нийт 0.8 сая төгрөгийн татварыг илүү суутган тооцсон, 0.3 сая төгрөгийн татварыг дутуу тооцсон байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 14.1 “энэ хуулийн 7.1 заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал.... орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна”, 23.1 “албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1....-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ”, 28.1 “албан татвар төлөгч, суутган төлөгчийн энэ хуулийн 27.1, ... -д заасны дагуу хүргүүлсэн тайлангаар албан татварын илүү, дутуу төлөлтийн тооцооллыг харьяа татварын алба дараах журмаар нягталж, эцсийн тооцоог хийнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын хуулийг хэрэгжүүлж ажиллах, татварын албатай жилийн эцсийн татварын үлдэгдлийг баталгаажуулж илүү төлсөн албан татварыг буцаан авах бусад татварт шилжүүлэн тооцох ажлыг тухай бүр хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Улсын авто замын сан-Төлбөр авах цэг	АХГ-2022/05/НА-СТА-ЗГТС	Нэр бүхий 3 ажилтанд амралтын цалинг илүү тооцож олгосон байна.	Ээлжийн амралтын тооцооллыг зөв хийж байх, буруутай албан тушаалтнаар хохирлыг нөхөн төлүүлэх	1	396.1	-	-	1	396.1	-	-	-	-
2	Улсын авто замын сан-Төлбөр авах цэг	АХГ-2022/05/НА-СТА-ЗГТС	Удирдлагын шийдвэр, цагийн бүртгэлгүй нэр бүхий 8 ажилтанд баяр ёслолын нэмэгдэл цалин, 7 ажилтанд цагийн бүртгэлийн системээр баталгаажуулаагүй илүү цагийн хөлс олгосон, нэр бүхий ажилтанд үр дүнгийн урамшуулал олгохдоо хөдөлмөр дотоод журам, ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журамд нийцүүлээгүй нийт 12,094.6 мянган төгрөгийн зөрчил илэрч байна.	Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журмыг мөрдөж ажиллах	1	12,094.6	-	-	-	-	1	12,094.6	-	-

Улсын авто замын сан – Төлбөр авах цэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	Улсын авто замын сан-Төлбөр авах цэг	АХГ-2022/05/НА-СТА-ЗГТС	Төлбөр авах цэгээр дамжин өдөр тутам олон удаагийн давтамжаар үйлчлүүлж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүстэй гэрээ байгуулан төлбөрийг авч байгаа боловч гэрээний дүнгээр төлбөрийн авлага үүсгэхгүй төлбөр хийгдсэн тухай бүр бүртгэж байна.	Гэрээний дагуу олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг урьдчилж орсон орлогоор бүртгэж төлбөр хийгдсэн гүйцэтгэлээр төлбөрийн орлогыг хүлээн зөвшөөрч гэрээг дүгнэж, тооцоо нийлсэн актаар авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулж байх.	1	-	-	-	-	-	-	-	1	-
4	Улсын авто замын сан-Төлбөр авах цэг	АХГ-2022/05/НА-СТА-ЗГТС	ХХОАТ тооцооллыг жилийн дүнгээр тулган баталгаажуулахад ажилчдаас нийт 801.5 мянган төгрөгийг татварыг илүү суутган тооцсон, 275.5 мянган төгрөгийн татварыг дутуу тооцсон байна.	Хувь хүний орлогын албан татварын хуулийг хэрэгжүүлж ажиллах, татварын албатай жилийн эцсийн татварын үлдэгдлийг баталгаажуулж илүү төлсөн албан татварыг буцаан авах бусад татварт шилжүүлэн тооцох ажлыг тухай бүр хэрэгжүүлж ажиллах	1	-	-	-	-	-	-	-	1	-
Дүн					4	12,490.7	-	-	1	396.1	1	12,096.6	2	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
Дүн					-	-	-	-	-	-	-	-	-	-
НИЙТ ДҮН					4	12,490.7	-	-	1	396.1	1	12,096.6	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 25

№ 144/АО150258

Улаанбаатар хот

АХТ-2022/05/ХА-СТА-Т213

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Улсын авто замын сан-Төлбөр авах цэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд нэр бүхий гурван ажилтанд ээлжийн амралтын олговор 396,066.84 төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 "Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Нэр бүхий гурван ажилтанд ээлжийн амралтын 396,066.84 /гурван зуун ерэн зургаан мянга жаран зургаан/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн төвийн захирал Х.Пүрэвжаргал, төлбөр авах цэгийн нягтлан бодогч Ц.Мөнхтуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Д.ГАНДОЛГОР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 703/А0150258

Улаанбаатар хот

АХТ-2022/05/НА-ОА-ЗТТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Улсын авто замын сан-Төлбөр авах цэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд удирдлагын шийдвэр, цагийн бүртгэлгүй нэр бүхий 8 ажилтанд 3,583,874.29 төгрөгийн баяр ёслолын нэмэгдэл цалин, 7 ажилтанд цагийн бүртгэлийн системд баталгаажуулаагүй 3,785,684.21 төгрөгийн илүү цагийн хөлс олгосон, нэр бүхий ажилтанд 4,725,000.00 төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалинг Хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журмын дагуу олгоогүй, нийт 12,094,558.50 төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын 2019 оны А/15 дугаар тушаалаар баталсан Зам, тээврийн хөгжлийн төвийн хөдөлмөрийн дотоод журмын 10 дугаар зүйлийн 10.2.9 "....төлбөр авах нэгж, замын ашиглалт, хөдөлгөөний хяналтын хэлтэс... хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ажилласан илүү цагийг цагийн бүртгэл, нотлох баримтын дагуу төвийн захирлын тушаалаар олгоно", Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын 2019 оны А/56 дугаар тушаалаар баталсан Зам, тээврийн хөгжлийн төвийн ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журмын 9 дүгээр зүйлийн 9.1 "үр дүнгийн гэрээний үнэлгээг үндэслэн дараах хувь хэмжээгээр үндсэн цалингаас тооцон үр дүнгийн урамшууллыг улирал бүр олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэр бүхий ажилчдад олгосон нэмэгдэл, урамшуулалт цалинг Хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журмын дагуу олгох, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн төвийн захирал Х.Пүрэвжаргал, төлбөр авах цэгийн нягтлан бодогч Ц.Мөнхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ийн
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Д.ГАНДОЛГОР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-314.Docx

0001091652

[illegible]